

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГАД ХИЙСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

Д.Сарантуяа

Хураангуй: Энэхүү илтгэлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа сургууль, цэцэрлэгийн багш нарын өнөөгийн байдлыг тодруулах судалгаа болон тэдний хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа арга, тусгай мэргэжлийн багш нарын хэрэглэдэг тусгай аргын талаар өгүүлнэ. Үүнийг үндэслэн нийтлэг арга байж болохыг та бүхэнд толилуулж байна.

Түлхүүр үг: арга, тусгай арга, нийтлэг арга

Үндэслэл

Нийгэм улс төр, эдийн засаг соёл олон нийтийн үйл ажиллагаанд хүн бүрийг тэгш боломжтойгоор оролцуулж аливаа ялгаварлах тусгаарлах хандлагыг арилгах нь өнөөгийн нийгэмд тохиолдож байгаа нэгэн чухал асуудал болж байна Энэ нь хүүхдийн эрхийн түгээмэл тунхаглал, хүүхдийн эрхийн конвенц, бух нийтийн болон тусгай хэрэгцээт боловсролын талаарх дэлхийн чуулгануудаас дэвшүүлсэн үзэл санааг хэрэгжүүлэх асуудалтай холбоотой юм. Бүх нийтийн боловсролын нэг зорилт бол “бага насны хүүхдийн ялангуяа эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалалт, боловсролын үйлчилгээг өргөжүүлэн сайжруулах” [4] юм.

Манай оронд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг интеграцчилан сургах Данида төсөл 1994- 1998 онд хэрэгжсэн. 1998 оноос одоог хүртэл ХИС /Их Британи/ хэрэгжүүлж байна. Тус Төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, тэдний сурах таатай орчныг бүрдүүлэх, тэдэнтэй ажиллаж байгаа багш нарт зориулсан сургалт зохион байгуулж байгаа. 2005-2007 онд Шведийн Олон улсын байгууллага SIDA, БСШУЯ-ны БДБГ - ын дэргэд багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга барилыг нь сайжруулах


зорилгоор төсөл хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн хүрээнд Шведийн олон улсын хөгжлийн агентлаг SIDA, БСШУЯ хамтран нэлээд номыг хэвлүүлэн гаргаад түгээж байна. Эдгээр төсөл хөтөлбөрүүд нь манай орны багш нар болон эцэг эхчүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах



тодорхой туршлагыг хуримтлуулж байгаа. Хэдий тийм боловч манай багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах аргагүй дутмаг

1. Ердийн сургууль цэцэрлэгийн багш нараас авсан судалгаа

Бид юуны өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нараас асуулгын аргаар судалгаа авсан юм. Уг судалгааны зорилго нь багш нарын аргагүйн мэдлэг хэр байгаа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад ном, гарын авлагын хэрэгцээ хэр хангагдаж байгааг илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг ямар аргууд байгааг тодруулахад оршиж байв.

Асуулгын судалгаанд Улаанбаатар, Баян-Өлгий, Баянхонгор аймгийн ЕБС, цэцэрлэгийн нийт 111 багш хамрагдлаа. Судалгаанд хамрагдсан багш нарын 54% нь сургуулийн, 46% нь цэцэрлэгийн багш нар (зураг 1) байсан. Харин насны ангиллаар авч үзвэл, 2040 насныхан 59%-ийг (зураг 2) эзэлж байгаа бөгөөд 6-20 жил ажилласан (зураг 3) багш нар 62%-ийг эзэлж байгаа туршлагатай олон жил ажилласан багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.





судалгаанд хамрагдсан багш нарын ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн 24.8 хувь нь харааны бэрхшээлтэй, 8.1 хувь нь сонсголын бэрхшээлтэй, 22.4 хувь нь хэл ярианы бэрхшээлтэй, 4.4 хувь нь бусад бэрхшээлтэй байгаа бөгөөд дийлэнх хувийг хэл ярианы бэрхшээл (зураг4) эзэлж байна.



Судалгаанаас харахад, багш нарт хамгийн хэрэгцээтэй зүйл нь аргазүйн чиглэлтэй ном гарын авлага байна гэж судалгаанд оролцогчдын 60.7% нь (зураг 5) хариулсан байгаа нь бидний Судалгааны ажлын хэрэгцээ шаардлагыг илгэж байна.

64.8 % нь дунд зэрэг, хангалтгүй (зураг 6) гэсэн хариултыг өгсөн нь бидний сонирхлыг татаж байна. Нөгөөтгээгүүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарт янз бүрийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон аргазүйн мэдлэг, чадвар эзэмшүүлэх хэрэгцээ шаардлага байгааг бидний асуулга судалгаа харууллаа.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг тусгай сургуулийн багш нарын заах аргад хийсэн судалгаа

Судалгааны үр дүнд багш нарт аргазүйн Мэдлэг боловсролоо байнга дээшлүүлэх хэрэгцээ их байгаа нь тогтоогдсон. Мөн Хөгжлийн янз бүрийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллахад шаардлагатай аргуудыг ангилж, бэрхшээл тус бүрийн онцлогт тохирсон аргуудыг гаргахыг хичээлээ. Үүний тулд бид СХУ, сэтгэл судлал, согог судлалын ном зохиол, Эх сурвалжид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиолддог бэрхшээлүүдийг засахад хэрэглэдэг аргуудыг манай орны багш сурган хүмүүжүүлэгчид, согогзүйчид (Я.Цэвээнлхазал, Д.Батхүү, Ч.Ганбилэг, С.Чимэддулам, Д.Хорлоо, Ц.Батжаргал, Н.Нямсүрэн, М.Ганцэцэг) өөрийн сургах ажилдаа хэрэглэдэг аргад анализ хийлээ. Мөн согогзүйч багшийн хичээлд суух болон ярилцлагын аргаар тусгай аргуудыг тодруулан гаргасан. Үүний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг тусгай болон нийтлэг аргууд байж болохыг гаргасан (хүснэгт 1) билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах тусгай болон нийтлэг аргууд Хүснэгт 1

Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга [2]: 1.Хэл ярианд сургах арга -авиа тавих, засах -арга дуу авиа засах арга -дактиль хэлэнд сургах арга -биет зүйл ашиглан үйл ажиллагааны явцад хэл ярианд сургах арга -бичгийн хэлэнд сургах арга - уруулаас уншуулж сургах арга - зориудын нөхцөл бүрдүүлэн ажиллах арга 2. Сонсгол хөгжүүлэх арга - ялган сонсох чадварыг хөгжүүлэх арга -техник хэрэгсэл ашиглах арга -ганцаарчлан ажиллах арга -анги нийтээр ажиллах арга 3.дохионы хэлэнд сургах арга -шинэ үгийг таниулах арга -үггүй жүжигчилсэн тоглолтын арга	Оюун ухааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга[4]: 1. Сэтгэхүйн үйлдэлд сургах арга - Юмс үзэгдлийн холбоог тогтоолгох арга - Ялган салгах чадварт сургах арга - Дэс дараалалтай ерөнхийлөн дүгнэх арга 2. Бие даах чадварт сургах арга - Хүний үгийг гүйцэд сонсож чаддаг болгох арга -Дэг журам, сахилга батыг мөрдүүлэх арга -Аливаа ажлын зорилго чиглэлийг ойлгуулах -Өөрийнх нь алдааг мэдүүлж сургах арга - Эхэлсэн ажлыг дуусгуулах арга 3. Харилцан ярианы арга - Ганцаарчлан ярилцах арга - Хэсгээр ярилцах арга - Асуултад хариулах арга 4. Дагуулан дуурайлгах арга - Өөрийн биеэр үлгэрлэн үзүүлэх арга - Дагуулж хийлгэх арга - Хүүхдийг хүүхдээр хүмүүжүүлэх арга 5. Урамшуулан дэмжих арга 6. Тоглоомын арга	
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах нийтлэг аргууд: - Дагуулан дуурайлгах арга - Тоглоомын арга - Туслах хэрэгсэл ашиглах арга - Бодит зүйлийг ашиглах арга - Урамшуулан дэмжих арга		
Харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга [3]: -Тэмтрэх мэдрэхүйг хөгжүүлэх арга -Хурууны мэдрэхүйг хөгжүүлэх арга -Тэмтрэх дасгал -Орон зайн баримжаа олгох арга -Орчиндоо биеэ авч явахад сургах арга -Таягны арга -Харилцан ярианы арга -Тоглоомын арга	Хэл ярианы бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга: 1.Дуурайх арга /амны хөдөлгөөн харж, хэлж сонсгох,биед мэдрүүлэх/ 2. Механик арга /тусгай зондын тусламжтайгаар тухайн авиаг хэлэхэд зориулж хэлний байрлалыг механик байдлаар өөрчлөх/ 3. Хосолсон арга 4. Тоглоомын арга /салхи шуугих, ус гоожих чимээг дуурайлган хэлүүлж тоглох, бар болж дуугарах гэх мэт/ 5. Эмчилгээний арга/ээрүү болон саажилттай хүүхдэд физик эмчилгээ, биеийн чадварт тохируулан чийрэгжүүлэх эмчилгээ 6.Өгүүлэх эрхтний хөдөлгөөн сайжруулах арга /13 дасгал/	Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга: 1. Булчингийн хөдөлгөөнийг сайжруулах арга -Идэвхтэй хөдөлгөөнийг сэргээх -Зөв хэвтүүлэх, байрлалыг байнга солих 2. Дасгалын арга - Туслах хэрэгслийн тусламжтайгаар хийлгэх -Хялбар дасгалаас хүндрүүлэх 3. хөдөлгөөнд хяналт тавьж сургах 4. Биеийн 2 талыг адил Хөгжүүлэх . 5.Тоглоомын арга

Дүгнэлт

Бид судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж байна.

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт аргазүйн чиглэлээр ном гарын авлага хэрэгцээтэй байгаа нь бидний судалгаанаас харагдаж байна.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр бэрхшээлийн онцлог, төвшнөөс шалтгаалан ялгаатай байх бөгөөд түүнд тохирсон нийтлэг хийгээд тусгай аргууд байна.

Санал

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт аргазүйн чиглэлийн ном гарын авлага хэрэгцээтэй байгаа ба үүнийг шийдвэрлэхэд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд багш нарт зориулсан ном гарын авлагыг гаргах шаардлагатай байна.

Ном зүй

1. Батцэнгэл. Г. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган, сэтгэлзүйн зарим асуудал, УБ., 2007.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах аргазүй сургалтын гарын авлага, УБ. 2005.
3. Хөгжлийн бэрхшээлийг танин мэдэхүй, УБ. 2007.
4. Сургалтын гарын авлага, УБ., 2008.